



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ
СПОРТЫН АРБИТР



СПОРТЫН АРБИТРЫН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ДҮРЭМ

2023 оны 12 дугаар сарын 01-ний
өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлнэ.

Удирдах зөвлөлийн 2023 оны 11 дугаар сарын 29-ны
өдрийн 23/21 тоот тогтоолын 01 дүгээр хавсралтаар батлаж,
2026 оны 09 дугаар сарын 11-ний өдрийн 26/10 тоот тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулав.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХЭРЭГЛЭХ ХҮРЭЭ

Нэгдүгээр зүйл. Ерөнхий зохицуулалт

- 1.1. Энэхүү дүрмийн зорилго нь спорттой холбоотой маргааныг хараат бус, шударга, үр ашигтай, шуурхай шийдвэрлэх арбитрын ажиллагааг зохион байгуулах, арбитрын бүрэлдэхүүн болон талуудын эрх, үүргийг тодорхойлоход оршино.
- 1.2. Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитр /цаашид "Спортын арбитр" гэх/-ын харьяалалд хамаарах олон улсын болон дотоодын арбитрын ажиллагаанд энэхүү дүрмийг хэрэглэнэ.
- 1.3. Арбитрын тухай Монгол Улсын хуулийн 52 дугаар зүйлийн 52.4 дэх хэсэгт заасны дагуу тус арбитраар маргаанаа шийдвэрлүүлэхээр талууд тохиролцсон бол энэхүү дүрмийг талуудын тохиролцоотой адилтган үзнэ.
- 1.4. Талууд өөрөөр тохиролцоогүй бол тухайн маргаанд Спортын арбитрын ажиллагаа эхэлсэн өдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дүрмийг баримтална.
- 1.5. Энэхүү дүрэмд заагаагүй болон талууд тохиролцоогүй аливаа ажиллагааг Спортын арбитрын бүрэлдэхүүн (цаашид “Бүрэлдэхүүн” гэх) аль тохиромжтой, аль нэг талын эрх зүйн байдлыг дордуулахгүй хэлбэрээр явуулна.
- 1.6. Талууд маргаанаа энэхүү дүрмийн дагуу шийдвэрлүүлэхээр тохиролцсон бол Спортын арбитрын харьяаллын маргаан гэж үзнэ.
- 1.7. Спортын арбитрын үйл ажиллагаанд спортын байгууллагыг өмчийн хэлбэрээр нь, мэргэжлийн, мэргэжлийн бус ангиллаар, тамирчныг улсын харьяалал, харьяат бус гэдгээр нь, арьс өнгө, шашин шүтлэг, нас, хүйс, мэргэжил боловсрол, багийн харьяалал, спортын цол, зэрэг, хөрөнгө чинээг үл харгалзах, ялгаварлан гадуурхахгүй байх зарчим дээр тулгуурлан явагдана.
- 1.8. Монголын хүүхдийн, оюутны, үндэсний, бүх ард түмний спортын их наадам, Үндэсний хэмжээний болон Монгол Улсад зохиогдож буй олон улсын хэмжээний тэмцээн, уралдаан, наадам, Улсын аварга шалгаруулах тэмцээн, Үндэсний их баяр наадам /Үндэсний бөхийн барилдаан, хурдан морины уралдаан, үндэсний сурын харваа/, орон нутгийн /аймаг, сум, баг/ чанартай, салбарын, байгууллагын зэрэг бүхий л спортын арга хэмжээний хүрээнд хийгдсэн аливаа гэрээ, дүрэм, журам, хэлэлцээрээс үүссэн маргааныг зохицуулахад энэхүү дүрэм хамаарна.
- 1.9. Спортын арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмээр шийдвэрлэхдээ Олон улсын болон Монголын эрх зүйн ерөнхий нийтлэг шаардлагад нийцүүлэхээс гадна олон улсын стандартад, Арбитрын “Загвар хууль”, Олон улсын Спортын конвенци, Олимпын Харти, Спортод сэргээш хэрэглэхийн эсрэг олон улсын конвенци, Арбитрын тухай хууль, Биеийн тамир, спортын тухай хууль, Үндэсний их баяр наадмын тухай хууль, Дэлхийн допингийн эсрэг дүрэм болон олон улсын стандарт, олон улсын худалдааны практикыг баримтална.
- 1.10. Энэхүү дүрмийн оноосон нэр томъёо дараах утга, агуулгыг илэрхийлнэ.
“Загвар хууль” гэдэг нь НҮБ-ын Олон улсын худалдааны эрхийн комиссоос 1985 оны 06 дугаар сарын 21-ний өдөр гаргасан “Олон Улсын Арилжааны Арбитрын “Загвар хууль”- ийг;
“Сэргээшийн эсрэг тунхаглал” гэдэг нь Спортод сэргээшийн эсрэг Копенгагены тунхаглалыг хэлнэ;

“Спортод сэргээш хэрэглэхийн эсрэг олон улсын конвенц” гэдэг нь Монгол улсын нэгдэн орсон конвенцийг хэлнэ;

“Олимпын Харт” гэдгийг Олон улсын олимпын хорооноос баталж 2011 оны 7 дугаар сард хүчин төгөлдөр болсон баримт бичгийг;

“Дэлхийн допингийн эсрэг дүрэм” нь 2003 онд анх батлагдаж 2004 онд хүчин төгөлдөр болсон. Уг дүрэмд нийт дөрвөн удаа өөрчлөлт орсон бөгөөд 2009 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр анхны өөрчлөлт, 2015 оны 1 дүгээр сарын 01-ний өдөр хоёр дахь удаагийн өөрчлөлт, 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр гурав дахь удаагийн өөрчлөлт, 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдөр дөрөв дэх удаагийн өөрчлөлтийг тус тус оруулсан байна. 2021 оны шинэчлэгдсэн Дэлхийн Допингийн эсрэг дүрэм нь 2021 оны 01 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлснийг;

“Биеийн тамир, спортын тухай хууль” гэж Монгол Улсын Их хурлаас 2017 оны 07 дугаар сарын 06-ны өдөр баталж 2018 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн хуулийг хэлнэ. Энэ хуулийн зорилт нь биеийн тамир, спортын салбарын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа, эрх зүйн үндсийг тодорхойлж, биеийн тамир, спортын салбарын харилцааг зохицуулахад оршино.

“Үндэсний их баяр наадмын тухай хууль” гэж Монгол Улсын Их хурлаас 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдөр баталсан хуулийг хэлнэ. Энэ хуулийн зорилт нь Үндэсний их баяр наадмыг улс орон даяар тэмдэглэн өнгөрүүлэх, Үндэсний их баяр наадмын хүрээнд үндэсний бөхийн барилдаан, сурын харваа, үндэсний хурдан морины уралдаан, шагайн харвааг зохион байгуулах, цол, чимэг олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

“Олон улсын стандарт” гэж Дэлхийн Допингийн эсрэг дүрмийг дэмжих зорилгоор WADA-аас баталсан стандартыг хэлнэ. Олон улсын стандартыг дагаж мөрдөх (өөр өөр стандарт, практик эсвэл процедурын эсрэг) нь олон улсын стандартад заасан журмыг зохих ёсоор гүйцэтгэсэн гэж үзнэ. Олон улсын стандартад олон улсын стандартын дагуу гаргасан техникийн баримт бичиг мөн багтана.

“Улсын Дээд шүүхийн тогтоол” гэж Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтад заасныг хэлнэ.

- 1.11. Арбитрын тухай хуульд заасан заавал дагаж мөрдөх заалтаас бусад ажиллагааг энэхүү дүрэмд заасны дагуу явуулна.
- 1.12. Энэхүү дүрэм нь Монголын Олон улсын ба Үндэсний Спортын арбитрын холбооны Удирдах зөвлөлөөс баталсан журам, бусад дүрэм, журам, заавар, зөвлөмжөөс бүрдэнэ.
- 1.13. Энэхүү дүрмийн зорилго нь тухайн төрөлжсөн спортын хүрээнд үүссэн аливаа маргааныг зөвхөн хуульд захирагдан, шударга ёсны зарчимд нийцүүлэн, алагчлалгүй, талуудын тэгш эрхийг бүрэн хангаж, голчтой, шударгаар шийдвэрлэхэд оршино.

Хоёр. Спортын арбитрын хэлэлцээр, харьяалал

- 2.1. Дараах маргааныг спортын арбитрын хэлэлцээртэй гэж үзнэ.
 - 2.1.1. Талууд маргааныг спортын арбитраар шийдвэрлүүлэхээр гэрээгээр харилцан тохиролцсон
 - 2.1.2. Талууд маргааныг спортын арбитраар шийдвэрлүүлэхээр дүрэм, журамдаа заасан;
 - 2.1.3. Талуудын гэрээ, дүрэм, журмын нэг хэсэг болсон арбитрын заалтыг гэрээний бусад нөхцөлөөс бие даасан гэж үзнэ.
- 2.2. Бүрэлдэхүүн арбитрын харьяаллын маргаан мөн эсэхийг өөрөө тогтооно.

- 2.2.1. Тамирчин зөрчигдсөн эрхээ хамгаалахаар спортын арбитрт хандсан бол;
 - 2.2.2. Спортын холбоод, клуб, тамирчин, дасгалжуулагч, сонирхогч этгээд спортын арбитрт хандсан (хүсэлт гарган) бол;
 - 2.2.3. Талууд гэрээ, дүрэм, журамдаа спортын арбитрыг тусгайлан заагаагүй боловч аль нэг тал нь эхэлж Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитрт нэхэмжлэл гаргасан бол;
 - 2.2.4. Бусад нөхцөл байдал
- 2.3. Эдгээр маргаан нь спорттой холбоотой зарчимууд, спортоор хичээллэх, хөгжүүлэхтэй холбоотой санхүүгийн болон бусад ашиг сонирхол эсвэл спорттой холбоотой аливаа үйл ажиллагаатай холбоотой байж болно.
 - 2.4. Гэрээ, дүрэм, журмын арбитрын заалтаас гадна арбитрын хэлэлцээрээс үүссэн түүнчлэн спортын хороо, холбоо, клуб, гишүүн, тамирчин, дасгалжуулагч, шүүгч спортын аливаа байгууллагын холбогдох баримт бичигт Спортын арбитрт давж заалдах гомдол гаргахаар заасан бол энэхүү дүрмийг баримтална.
 - 2.5. Бүрэлдэхүүн талуудтай тохиролцон арбитрын ажиллагаа болон хуралдааныг хаана ч явуулж болно. Энэ нь харьяаллыг зөрчсөн гэж үзэх үндэслэл болохгүй.
 - 2.6. Талууд харьяаллын талаар гомдол гаргахаар бол нэхэмжлэлд тайлбар гаргахаасаа өмнө Бүрэлдэхүүнд гаргана.
 - 2.7. Талуудын хооронд маргааны асуудлаар ижил асуудлаар шүүх эсвэл өөр арбитрт ажиллагаа явагдаж байгаа аливаа хууль зүйн ажиллагаанаас үл хамааран маргаан нь өөрийн харьяаллынх мөн эсэхийг Бүрэлдэхүүн шийдвэрлэнэ.

**Гурав. Маргаан шийдвэрлэхэд хэрэглэх
эрх зүйн хэм хэмжээ**

- 3.1. Арбитрын тухай хууль, Биеийн тамир, спортын тухай хууль, Үндэсний баяр наадмын тухай хууль, хуулийг тайлбарласан Улсын Дээд шүүхийн тогтоол, холбогдох спортын холбооны дүрэм, журам, тэмцээн уралдааны дүрэм, журам болон талуудын гэрээ, (Дэлхийн Допингийн эсрэг дүрэм, Допингийн эсрэг үндэсний болон Олон улсын стандартаар хязгаарлагдахгүйгээр) НҮБ-ын олон улсын арилжааны эрхийн комитсоос гаргасан арбитрын “Загвар хууль”, Олимпын Харти, дэлхийн бусад улс орнуудын арбитрын хэрэг шийдвэрлэж буй нийтлэг жишиг, олон улсын спортын харилцааны ёс, зан заншил, уламжлал нь хэрэг, маргааныг шийдвэрлэх эрх зүйн хэм хэмжээ, харгалзах эх сурвалж болно.
- 3.2. Бүрэлдэхүүн хэргийн агуулгад тохирох хэмжээгээр талуудын сонгосон эрх зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө. Талууд ийнхүү тохиролцоогүй бол Бүрэлдэхүүн талуудын байгуулсан гэрээний заалт болон тохиромжтой гэж үзсэн эрх зүйн хэм хэмжээ, олон улсын гэрээ, зан заншлыг харгалзан үзнэ.
- 3.3. Зөвхөн талууд шууд эрх олгосон онцгой тохиолдолд Бүрэлдэхүүн аливаа хуулийг хэрэглэхгүйгээр, шударга гэж үзсэн ёс зүйн хэм хэмжээ, амьдралын хар ухааны зөв сургамжит ухагдахуун, ардын ухаалаг ур дүй, тухайн улс үндэстэний зан заншилд нийцүүлэн маргааныг шийдвэрлэж болно.
- 3.4. Гадаад улсын хуулийг хэрэглэх тохиолдолд тухайн хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалт, хуулийн албан ёсны тайлбар, тухайн төрлийн хэргийг хэрхэн шийдвэрлэж

ирсэн практикийг харгалзан жишиж үзэж болно.

- 3.5. Гэхдээ хэрэг нь олон улсын байсан ч Спортын арбитр хэргийг хянан шийдвэрлэхдээ Арбитрын тухай Монгол Улсын хуулийн “Арбитрын хэлэлцээр ба шүүхэд нэхэмжлэл гаргах, арбитрын шийдвэрийн биелэлтийг баталгаажуулахад шүүхээс авах арга хэмжээ, зардал, хохирлыг гаргуулах, түр арга хэмжээг хүлээн зөвшөөрөх, гүйцэтгэх, шүүхээс авах түр арга хэмжээ, нотлох баримт бүрдүүлэхэд шүүхээс туслалцаа үзүүлэх, үндсэн шийдвэрийг хүлээн зөвшөөрч гүйцэтгэх, үндсэн шийдвэрийг гүйцэтгэхээс татгалзах” зохицуулалтыг хэрэглэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ.

СПОРТЫН АРБИТРЫН МАРГААН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

Дөрөв. Нэхэмжлэл гаргах

- 4.1. Спорттой холбоотой эсхүл спортын байгууллага, тамирчин, гишүүд холбоотой өөрийн эрх, эрх чөлөө, ашиг сонирхол хохирсон гэж үзэж байгаа хуулийн этгээд, иргэн тухайн спортын холбоо, нийгэмлэг, клуб эсхүл тийм ижил төрлийн байгууллагад маргааныг шийдвэрлэх бүтэц, зохион байгуулалт, Бүрэлдэхүүн байхгүй, эсхүл уг маргааныг шийдвэрлэхээс татгалзсан, энэхүү дүрэмд заасан хугацаанд маргааныг шийдвэрлээгүй, эсхүл гаргасан шийдвэрийг нь эс зөвшөөрч байгаа бол Спортын арбитрт шууд хандах эрх нь нээлттэй.
- 4.2. Нэхэмжлэлийг Спортын арбитрын Ажлын албанд биечлэн эсхүл баталгаат шуудангаар ирүүлж болно.
- 4.3. Нэхэмжлэлд дараах мэдээллийг тусгаж, баримтыг бүрдүүлнэ. Үүнд:
- 4.3.1. Талуудын нэр, хаяг, утас, цахим шуудан, шуудангийн хаяг, эрх бүхий этгээд, төлөөлөгчдийн мэдээлэл, холбоо барих бүх мэдээлэл
- 4.3.2. Нэхэмжлэлийн шаардлага, мөнгөн дүн
- 4.3.3. Нэхэмжлэл гаргах болсон үндэслэл, маргааны агуулгыг тодорхой заах
- 4.3.4. Иргэн бол иргэний үнэмлэх, хуулийн этгээд бол гэрчилгээний хуулбар
- 4.3.5. Спортын арбитрын хэлцэл, гэрээ, дүрэм, журам болон холбогдох баримт бичиг
- 4.3.6. Спортын арбитрын зардал төлсөн баримт
- 4.3.7. Хэдэн арбитрчаар маргааныг шийдвэрлүүлэх хүсэлт, арбитрч сонгосон бол нэрийг сонгосон тухай мэдэгдэл
- 4.4. Нэхэмжлэлд дараах мэдээллийг нэмэлтээр тусгаж болно. Үүнд:
- 4.4.1. Итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцуулах бол итгэмжлэл
- 4.4.2. Нэхэмжлэлийн хууль зүйн үндэслэл эсхүл нэхэмжлэлээ дэмжсэн нэмэлт тайлбар
- 4.4.3. Спортын арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ач холбогдолтой гэж үзсэн мэдээлэл, баримтуудыг гарган өгч болно.
- 4.4.4. Спортын арбитрын ажиллагаа явуулах газар, хэл, хэрэглэх хууль, дүрмийн талаарх тусгайлсан хүсэлт
- 4.5. Нэхэмжлэл, түүний хавсралт, хариуцагчийн тайлбар, сөрөг нэхэмжлэл түүний хавсаргасан материалыг арбитрын хэргийн хавтас, хэргийн оролцогчид болон арбитрчдын тоогоор хувилж өгнө.
- 4.6. Талууд тохиролцсон бол тухайн хэл дээр, тохиролцоогүй бол Монгол хэл дээр

нэхэмжлэлийг гаргана. Гадаад хэл дээр гаргаж байгаа нэхэмжлэл, түүнд хавсаргасан аливаа баримт бичгийг Монгол хэл рүү, эсхүл тухайн хэл рүү баталгаат орчуулгаар орчуулуулсан байна.

- 4.7. Хэрэв үндсэн хуралдаан эхэлмэгц шаардлага хангасан сөрөг нэхэмжлэл гаргасан, эсхүл нэхэмжлэлийн шаардлагаа өөрчилсөн бол талуудад шинээр гаргасан нэхэмжлэлтэй танилцах, дахин тайлбар хийх, шинэ нотлох баримт бүрдүүлэх боломж олгож хуралдааныг хойшлуулж болно. Гэхдээ нөгөө тал нь сөрөг нэхэмжлэл, нэхэмжлэлийн өөрчилсөн шаардлагыг хүлээн зөвшөөрч хуралдааныг үргэлжлүүлэх хүсэлт гаргасан бол хуралдааныг ердийн журмаар үргэлжлүүлнэ.
- 4.8. Ажлын албаны даргаас хэрэг үүсгэсэн тухай мэдэгдлийг нэхэмжлэгч, хариуцагч нарт хүргүүлнэ.
- 4.9. Талууд арбитрад энэ дүрмийн 4.3.1-т заасан гаргаж өгсөн мэдээллийнхээ үнэн зөвийг өөрсдөө бүрэн хариуцах бөгөөд уг мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд нэн даруй арбитрад мэдэгдэнэ. Хэрэв мэдэгдээгүйгээс үүсэх үр дагаварыг талууд өөрсдөө хариуцана.

Тав. Нэхэмжлэлийг буцаах

- 5.1. Нэхэмжлэлийг буцаах үндэслэлүүд. Үүнд:
 - 5.1.1. Спортын арбитрын харьяаллын бус маргаан
 - 5.1.2. Урьдчилан шийдвэрлэх ажиллагааг зөрчсөн маргаан
 - 5.1.3. Эрхийн чадамжгүй буюу төлөөлөх эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан
 - 5.1.4. Нэхэмжлэлд дурдсан асуудлыг шийдвэрлэсэн шүүхийн буюу арбитрын хүчин төгөлдөр шийдвэр байгаа бол
 - 5.1.5. Нэхэмжлэлийн бүрдүүлбэрийн шаардлага хангагдаагүй
- 5.2. Нэхэмжлэлийг бүрдүүлбэр хангаагүй шаардлагаар буцаасан бол бүрдүүлбэрийн шаардлагыг хангаж дахин нэхэмжлэл гаргаж болно.

Зургаа. Нэхэмжлэлийн үнэ

- 6.1. Нэхэмжлэлийн үнийн дүнг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:
 - 6.1.1. Мөнгө төлүүлэхээр шаардсан нэхэмжлэлд нэхэмжилж байгаа мөнгөн дүнгээр,
 - 6.1.2. Гэрээ хэлцлийг хүчин төгөлдөр бусад тооцуулах тухай нэхэмжлэлд уг гэрээ хэлцлийн үнийн дүнгээр,
 - 6.1.3. Эд хөрөнгө гаргуулахаар шаардсан нэхэмжлэлд нэхэмжилж байгаа эд хөрөнгийн үнийн дүн, үнийн дүнг тодорхойлох боломжгүй бол тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр,
 - 6.1.4. Эрхийн харилцааг хүлээн зөвшөөрөх буюу өөрчлөх тухай нэхэмжлэлд нэхэмжлэл гаргах үе дэх эрхийн харилцааны зохицуулах зүйлийн өртгөөр,
 - 6.1.5. Тодорхой үйлдэл буюу эс үйлдлийн тухай нэхэмжлэлд нэхэмжлэгчийн эд хөрөнгийн сонирхлын талаар байгаа мэдээллийг үндэслэн заана.
 - 6.1.6. Хэд хэдэн шаардлага тавьсан нэхэмжлэлд, шаардлага бүрийн үнийн дүнг тус бүрт нь тодорхойлох бөгөөд нэхэмжлэлийн үнийг бүх шаардлагын нийлбэр дүнгээр тодорхойлно.
- 6.2. Хэрэв нэхэмжлэгч нэхэмжлэлийн үнийн дүнг тодорхойлоогүй эсхүл буруу

тодорхойлсон байвал Бүрэлдэхүүн өөрийн санаачилгаар, нэхэмжлэгчийн хүсэлт, эсхүл хариуцагчийн шаардлагаар нэхэмжлэлийн үнийн дүнг тодорхойлно.

- 6.3. Хэрвээ нэхэмжлэлийн үнийн дүнг тогтооход бэрхшээлтэй онцгой тохиолдолд холбогдох мэргэжлийн байгууллага болон мэргэжилтнээр тогтоолгож болно.

Долоо. Арбитрын зардал

- 7.1. Спортын арбитрын зардлын хэмжээ, төлөх, буцаах, зардлыг хуваарилах журмыг “Спортын арбитрын зардлын журам”-аар тодорхойлно.
- 7.2. Спортын арбитрын зардал нь үндсэн болон нэмэлт зардлаас бүрдэх бөгөөд үндсэн зардлыг арбитрт нэхэмжлэл гаргахдаа урьдчилан төлнө.
- 7.3. Үндсэн зардалд арбитрчдын хөлс, нарийн бичгийн болон захиргааны зардал багтана.
- 7.4. Талууд арбитрын ажиллагааны явцад гарсан дараах нэмэлт зардлыг Бүрэлдэхүүнээс тогтоосон хугацаанд төлнө.
- 7.4.1. Шинжээчтэй холбогдон гарах зардал, арбитрын шийдвэрээр гүйцэтгэсэн ажиллагаа нь тухайн этгээдийн үндсэн ажил үүрэгт хамаарахгүй бол тэдгээрийн ажлын хөлс,
- 7.4.2. Үзлэг хийхэд гарсан зардал, томилолтын зардал,
- 7.4.3. Арбитрын байнгын байрлах газраас өөр газарт арбитрын ажиллагаа, хуралдаан явуулсантай холбогдсон зардал,
- 7.4.4. Шуудангийн зардал, мэргэжлийн байгууллага болон мэргэжилтний хөлс, хэлмэрчлэл, орчуулга хийх, гэрчийн зардал, арбитрчдын болон нарийн бичгийн томилолтын зардал
- 7.4.5. Бусад зардал.

Найм. Спортын арбитрын ажиллагааг эхлэх, тайлбар, сөрөг нэхэмжлэл гаргах

- 8.1. Талууд өөрөөр тохиролцоогүй бол арбитрын хэрэг үүсгэсэн тухай мэдэгдэл, хэрэг хянан шийдвэрлэх дүрэм, арбитрчдын нэрсийн жагсаалт болон нэхэмжлэл, түүнд хавсаргасан баримтыг хариуцагч талд энэхүү дүрмийн 10 дугаар зүйлд заасны дагуу хүргүүлснээр арбитрын ажиллагааг эхэлсэнд тооцно.
- 8.2. Талууд арбитрын хэрэг үүсгэсэн мэдэгдлийг хүлээн авмагц дотоодын маргааны хувьд 7 хоногийн дотор, олон улсын маргааны хувьд 14 хоногийн дотор хариу тайлбараа ирүүлж, арбитрч сонгож томилсон саналаа мэдэгдэнэ.
- 8.3. Арбитрын ажиллагаанд хэд хэдэн нэхэмжлэгч, хариуцагчид оролцож болох бөгөөд үндсэн болон сөрөг нэхэмжлэл, тайлбаруудыг тус бүрт нь хүргүүлнэ.
- 8.4. Хэд хэдэн нэхэмжлэгч, хариуцагч оролцож байгаа тохиолдолд сүүлчийн этгээдэд мэдэгдэл хүргүүлснээр хугацааг тоолно.
- 8.5. Хэрэв талууд тогтоосон хугацаанд хариу тайлбар ирүүлээгүй, арбитрчаа сонгож томилоогүй бол энэ дүрмийн дагуу арбитрын ажиллагааг цааш үргэлжлүүлнэ.
- 8.6. Хариуцагч үндсэн нэхэмжлэлтэй холбоотой асуудлаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болохоос өмнө сөрөг нэхэмжлэл гаргах эрхтэй. Сөрөг нэхэмжлэл нь энэ дүрмийн 5 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

- 8.7. Арбитрын ажиллагаа эхлэхээс өмнө эсхүл ажиллагааны явцад шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ авхуулах зорилгоор шүүхэд хүсэлт гаргаж болно. Энэ нь арбитрын хэлэлцээртэй ямар нэг байдлаар зөрчилдсөн гэж үзэхгүй.
- 8.8. Спортын арбитрын хуралдааны бэлтгэлийг хангах, хуралдааны явц, шийдвэрийг ёсчлох, албажуулах ажиллагааг Ажлын алба гүйцэтгэнэ.

Ес. Бичиг баримтыг хүргүүлэх, хугацаа тоолох

- 9.1. Талууд маргаанд холбогдох бүхий л баримт бичиг, мэдэгдлийг Ажлын алба эсхүл Бүрэлдэхүүнд хүргүүлнэ.
- 9.2. Талууд баримт бичгийг хүрэлцэн ирж авах бөгөөд боломжгүй бол талуудын мэдэгдсэн эсхүл хамгийн сүүлд мэдэгдэж байсан, түүний үйл ажиллагаа явуулдаг, эсхүл байнгын оршин суугаа, мөн үйл ажиллагаагаа байнга явуулдаг газар, шуудан болон цахим шуудан (емейл)-гийн хаягаар, харин эдгээрийг тогтоох боломжгүй бол гэрээний эсхүл эрх бүхий байгууллагаас ирүүлсэн лавлагаанд дурдсан хаягаар баталгаат шуудангаар хүргүүлнэ. Ийнхүү хүргүүлснээ баримтаар баталгаажуулсан бол хүлээн авсанд тооцно.
- 9.3. Баримт бичиг, мэдэгдлийг факс, телеграмм, цахим шуудан болон бусад техник технологийн хэрэгслийг ашигласан, шаардлагатай онцгой тохиолдолд хэвлэл мэдээллийн хэрэгслээр зар хүргэсэн, хүргэх оролдлого хийсэн /факс, мессеж, и-мэйл хаягаар г.м./ тэмдэглэл үйлдэх зэрэг боломжит бүх арга, хэрэгслийг ашигласан байвал хүлээн авсантай адилтган тооцно.
- 9.4. Бичиг баримт, мэдэгдлийг энэ зүйлийн 9.2, 9.3 дахь хэсэгт тус тус заасны дагуу хүргэсэн өдрийг зохих хугацаанд хүлээн авсан өдөрт тооцно.
- 9.5. Арбитрын ажиллагааны мэдэгдлийг хүлээн авагчид цахим шуудангаар эсхүл бусад цахим харилцаа холбоогоор илгээснийг хүлээн авсан өдөрт тооцно.
- 9.6. Мэдэгдэл, баримт бичгийг хүлээн авсан, арбитрын ажиллагааны өдрийг хуанлийн тооллоор, цагийг тухайн ажиллагаа явагдах улс, орны орон нутгийн цагаар тодорхойлно.
- 9.7. Хэрэв тогтоосон хугацааны сүүлийн өдөр нь амралтын, нийтээр амрах баяр ёслолын өдөр эсхүл хүлээн авагчийн оршин байгаа улс орон, бүс нутгийн нийтийг хамарсан баяр, амралтын өдөр бол энэ хугацаа нь дараагийн ажлын эхний өдрөөр тооцогдоно.
- 9.8. Хугацааг хуанлийн өдрөөр тоолох бөгөөд мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс тоолно. Хугацааг тооцохдоо албан ёсны нийтээр амрах баярын өдрүүд болон ажлын бус өдрүүдийг багтаасан.

ГУРАВДУГААР БҮЛЭГ БҮРЭЛДЭХҮҮН, ТҮҮНИЙ БҮРЭН ЭРХ

Арав. Бүрэлдэхүүнийг томилох журам

- 10.1. Талууд арбитрчаа Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитрын арбитрчдын нэрсийн жагсаалтаас сонгож томилно.
- 10.2. Бүрэлдэхүүн нэг буюу гурван арбитрчаас бүрдэнэ.
- 10.3. Талууд арбитрчийн тоог нэг байхаар тохиролцсон, эсхүл аль нэг тал нь нэг байх санал

гаргасан, нэг байх саналыг нөгөө тал нь хүлээн авснаас хойш 7 хоног (олон улсын маргаанд 14 хоног)-ийн дотор зөвшөөрсөн эсхүл томилоогүй, хариу өгөөгүй буюу татгалзаагүй тохиолдолд нэг арбитрчаар шийдвэрлүүлэх хүсэлтийг хүлээн зөвшөөрсөнд тооцох бөгөөд арбитрчийг Ерөнхийлөгч томилно.

- 10.4. Талууд өөр өөр саналтай бол Бүрэлдэхүүний тоо гурав байна. Гурван арбитрч оролцох бол тал тус бүр нэг арбитрчийг томилох ба томилогдсон хоёр арбитрч гурав дахь арбитрчийг томилно.
- 10.5. Талууд арбитрчийн тоог гурав байхаар тохиролцсон, эсхүл аль нэг тал нь гурав байх санал гаргасан, тухайн саналыг нөгөө тал нь хүлээн авснаас хойш 7 хоног (олон улсын маргаанд 14 хоног)-ийн дотор арбитрчаа сонгож томилоогүй, эсхүл хариу өгөөгүй буюу татгалзаагүй тохиолдолд гурван арбитрчаар шийдвэрлүүлэх хүсэлтийг хүлээн зөвшөөрсөнд тооцох бөгөөд уг хугацаанд сонгож томилоогүй талын арбитрчийг Ерөнхийлөгч томилно.
- 10.6. Талуудын томилогдсон арбитрчид томилогдсоноос хойш 7 хоног (олон улсын маргаанд 14 хоног)-ийн хоногийн дотор гурав дахь арбитрчийг сонгож санал нэгдвэл томилно. Гурав дахь арбитрч нь Бүрэлдэхүүн даргалагч арбитрчаар ажиллана.
- 10.7. Талуудын томилогдсон арбитрчид даргалагч арбитрчийн энэхүү дүрмийн 10.6-д заасан хугацааны дотор томилох ба тохиролцоонд хүрч чадаагүй бол Ерөнхийлөгч томилно.
- 10.8. Мэдэгдэлд заасан хугацаанаас өмнө талууд арбитрчаа, арбитрчид даргалагч арбитрчийг Ерөнхийлөгчөөр томилуулах хүсэлтийг гаргаж болно.
- 10.9. Арбитрын ажиллагаанд хэд хэдэн нэхэмжлэгч, хариуцагч оролцох тохиолдолд талууд арбитрчийн тоог өөрөөр тохиролцоогүй бол нэхэмжлэгчид хамтран нэг арбитрчийг, хариуцагчид хамтран нэг арбитрчийг 14 хоног (олон улсын маргаанд 30 хоног)-ийн дотор тус тус томилно.
- 10.10. Талууд арбитрчаа сонгохдоо тухайн арбитрчийн боловсрол, мэдлэг, ажлын дадлага туршлага, ёс зүй, хэрэг маргааныг шударгаар шийдвэрлэж чадна гэсэн өөрийн итгэл үнэмшилд тулгуурлана. Талуудын сонгож байгаа арбитрч нь тухайн сонгосон талд үйлчлэх, зөвлөгөө, тусалцаа өгөх үүрэггүй учраас талуудаас хараат бус, бие даасан байна.
- 10.11. Томилогдсон арбитрч нь энэхүү дүрэмд заасны дагуу өөрсдийн үйл ажиллагааг хараат бус, нөлөөнд автагдахгүйгээр явуулах мэдэгдэлд гарын үсэг зурна.
- 10.12. Ерөнхийлөгч арбитрчийг томилохдоо талуудын шаардлагыг хангаж байгаа эсэх, мэргэжил, мэргэшсэн байдал, дадлага туршлага, арбитрын хэргийг шийдвэрлэхэд оролцсон удаа, хэргийн болон ажлын ачаалал, цаг зав, хэлний чадвар болон бусад нөхцөл байдлыг харгалзан үзнэ.
- 10.13. Талууд өөрөөр тохиролцоогүй бол Бүрэлдэхүүн даргалагч, эсхүл нэг арбитрын Бүрэлдэхүүн нь хуульч мэргэжилтэй байна.
- 10.14. Энэхүү дүрмийн 10.3, 10.5, 10.7-д заасан асуудлаар гаргасан Ерөнхийлөгчийн шийдвэр нь эцсийнх байна.

Арван нэг. Арбитрчийн хараат бус байдал

- 11.1. Арбитрч нь хараат бус, бие даасан байх үүрэгтэй бөгөөд аливаа талын хувьд өөрийн хараат бус, бие даасан байдалд нөлөөлж болох аливаа нөхцөл байдлын талаар нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.
- 11.2. Арбитрч тухайн маргааныг хянан шийдвэрлэхдээ аливаа хөндлөнгийн нөлөөнд автахгүйгээр, зөвхөн өөрийн мэргэжлийн мэдлэг, ур чадвараа дайчилж шударгаар ажиллана.
- 11.3. Арбитрч нь арбитрчаар сонгогдсоноо хүлээн зөвшөөрсөн, хараат бус байдлын мэдүүлэгт, нууц хамгаалах мэдэгдэлд гарын үсэг зурсан үеэс хойш арбитрын аливаа ажиллагаанд оролцоно.
- 11.4. Арбитрчаар томилогдох хүсэлт авсан этгээд тухайн маргаанд ажиллахаа хүлээн зөвшөөрөхөөс өмнө талуудын талаарх мэдээлэл, нэхэмжлэлтэй танилцан өөрийн хараат бус, бие даасан байдалд эргэлзээ төрүүлэх нөхцөл байдал байгаа болон ажиллах бусад боломжгүй талаар Ажлын албанд мэдэгдэх үүрэгтэй. Үүнд:
- 11.4.1 Талуудын харилцан тохиролцсон шаардлагыг хангаж байгаа эсэх
- 11.4.2 Талуудтай аливаа маргаантай асуудлаар шүүх, арбитраар хэрэг хянан шийдвэрлэхэд хэргийн оролцогч, зохигч, гуравдагч этгээд, өмгөөлөгч, гэрч, шинжээч, орчуулагчаар оролцож байсан
- 11.4.3 Талууд, өмгөөлөгч, төлөөлөгч нь Бүрэлдэхүүнд байгаа арбитрчтай төрөл садан, хувийн харилцаатай, сүүлийн гурван жилийн байдлаар захирах, захирагдах харилцаанд байсан
- 11.4.4 Талуудад мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлж байсан, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчидтэй хамтран ажиллаж байсан, нэгдмэл сонирхолтой
- 11.4.5 Бусад нөхцөл байдлын улмаас хэргийг шударгаар шийдвэрлэж чадах талаар үндэслэлбүхий эргэлзээтэй байдал байгаа бол
- 11.5. Арбитрч нь дээрх нөхцөл байдал байгаа бол томилогдохоосоо өмнө болон томилогдсоныхоо дараа аль ч үед Ажлын алба, талуудад бичгээр мэдэгдэх үүрэгтэй бөгөөд ийнхүү мэдэгдэхдээ арбитрчаар ажиллах, эсхүл татгалзах тухай саналаа ирүүлнэ.

Арван хоёр. Арбитрчийг татгалзан гаргах үндэслэл, журам

- 12.1. Талуудын өөрөөр тохиролцоогүй бол арбитрчийг зөвхөн энэхүү дүрмийн 11.4 дахь хэсэгт заасан үндэслэлээр татгалзан гаргана.
- 12.2. Талууд арбитрчийн хараат бус байдлын мэдүүлгийг хүлээн авснаас хойш 7 хоног (олон улсын маргаанд 14 хоног)-ийн дотор илэрхий болсон үндэслэлээр түүнийг татгалзан гаргах тухай үндэслэл бүхий хүсэлтээ зөвхөн нотлох баримтаар баталгаажуулан гаргах бөгөөд хүсэлтийг Бүрэлдэхүүн шийдвэрлэнэ.
- 12.3. Арбитрчийг аль нэг талаас татгалзан гаргах тухай хүсэлт гаргаж байгааг нөгөө тал зөвшөөрсөн, арбитрч мөн татгалзан гаргах хүсэлт гарсны дараа өөрөө арбитрчаар ажиллахаас татгалзсан нь 11 дугаар зүйлийн 11.4 дахь хэсэгт заасан үндэслэлийг хүлээн зөвшөөрсөн гэж үзэхгүй.
- 12.4. Арбитрын ажиллагааны журам баталагдсанаас хойш арбитрчыг татгалзах хүсэлт гаргах бол Спортын арбитрын зардлын журмаар тогтоосон хэмжээгээр зардал төлж хавсаргана.

Арван гурав. Арбитрчийг нөхөн томилох

- 13.1. Арбитрчийг татгалзан гаргасан, арбитрч үүргээ удаан хугацаагаар гүйцэтгэх боломжгүй болсон, өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн, нас барсанаар бүрэн эрх дуусгавар болсон, ёс зүйн зөрчил гаргасан, үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй, арбитрын нэр төрд харшилсан үйлдлээр Ерөнхийлөгч арбитрчийн эрхийг түдгэлзүүлсэн эсэхүл дуусгавар болгосон бол арбитрчийг нөхөн томилно.
- 13.2. Бүрэлдэхүүн нөхөн томилогдсон бол өмнөх Бүрэлдэхүүний ажиллагаанаас хойш үргэлжлүүлэн явуулах эсэхийг талуудтай тохиролцон тодорхойлно. Нэг арбитрчаар шийдвэрлэх хэрэгт арбитрын ажиллагааг дахин эхлүүлнэ.
- 13.3. Талуудын сонгож томилсон аль нэг арбитрчийг нөхөн томилсон бол даргалагч арбитрчийг хэвээр үлдээх эсэхийг тухайн Бүрэлдэхүүн шийдвэрлэнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
АРБИТРААС ГАРАХ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТИЙГ
БАТАЛГААЖУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ, УРЬДЧИЛСАН ТОГТООЛ

Арван дөрөв. Шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах
талаарх Бүрэлдэхүүний бүрэн эрх

- 14.1. Аль нэг талын хүсэлтээр Бүрэлдэхүүн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ /цаашид "түр арга хэмжээ" гэх/ авч болно.
- 14.2 Түр арга хэмжээ гэдэгт маргааныг эцэслэн шийдвэрлэхээс өмнө үндсэн шийдвэрээр эсхүл бусад хэлбэрээр аль нэг талд үүрэг болгосон дараах хүрээнд авах түр арга хэмжээ хамаарна:
- 14.2.1. маргааныг эцэслэн шийдвэрлэх хүртэл одоогийн байгаа нөхцөл байдлаа хэвээр хадгалах, эсхүл сэргээх;
- 14.2.2. одоогийн эсхүл учирч болох хохирлыг нэмэгдүүлэх, эсхүл арбитрын ажиллагаанд бэрхшээл учруулах үйлдэл хийхгүй байх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;
- 14.2.3. арбитрын үндсэн шийдвэрийн биелэлтийг хангахад шаардлагатай байж болох хөрөнгийг хамгаалах арга хэмжээ авах;
- 14.2.4. маргааныг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой, уг маргаантай холбоотой байж болох нотлох баримтыг хамгаалах.

Арван тав. Түр арга хэмжээ авах нөхцөл

- 15.1. Энэхүү дүрмийн 14.2.1, 14.2.2, 14.2.3-т заасан түр арга хэмжээ авах тухай хүсэлт гаргасан тал дараах нөхцөлийг нотолно:
- 15.1.1. Тухайн арга хэмжээг аваагүй тохиолдолд үндсэн шийдвэрийн дагуу төлүүлж болох хохирлыг хангалттай барагдуулах боломжгүй бөгөөд уг хохирлын хэмжээ нь тухайн арга хэмжээг авсны улмаас уг арга хэмжээнд холбогдох этгээдэд учирч болох хохирлоос үлэмж их байх;
- 15.1.2. маргааныг хүсэлт гаргагч талд ашигтайгаар шийдвэрлэх үндэслэлтэй магадлал байгаа;
- 15.1.3. энэхүү дүрмийн 14.2-т заасан түр арга хэмжээг авхуулах хүсэлт тодорхой, ойлгомжтой, хэрэгжихүйц байх.

- 15.2. Энэхүү дүрмийн 15.1.2-т заасан магадлалыг тогтоох нь цаашид шийдвэр гаргах Бүрэлдэхүүний дотоод итгэл үнэмшилд нөлөөлөхгүй.
- 15.3. Гагцхүү Бүрэлдэхүүн шаардлагатай гэж үзсэн бол энэхүү дүрмийн 14.2.4-т заасан арга хэмжээ авхуулах тухай хүсэлтэд энэхүү дүрмийн 15.1.1, 15.1.2-т заасан нөхцөл нэгэн адил хамаарна.

**Арван зургаа. Урьдчилсан тогтоол гаргуулах тухай
өргөдөл, урьдчилсан тогтоол гаргах нөхцөл**

- 16.1. Талууд өөрөөр тохиролцоогүй бол нэг тал нь бусад талдаа мэдэгдэхгүйгээр түр арга хэмжээ авхуулах тухай хүсэлтээ тухайн арга хэмжээний зорилгод хүрэхэд саад учруулахгүй байхыг үүрэг болгосон урьдчилсан тогтоол гаргуулах өргөдөлд хавсаргаж болно.
- 16.2. Түр арга хэмжээ авах тухай нэг талын хүсэлтийг хүлээн авсан Бүрэлдэхүүн хүсэлтийг талуудыг оролцуулахгүй хэлэлцээд хүсэлтийг хангасан эсхүл татгалзсан эсэх талаар тогтоол гаргана.
- 16.3. Бүрэлдэхүүн урьдчилсан тогтоолыг талуудад хүргүүлэхдээ түр арга хэмжээний мэдээллийг хавсаргана.
- 16.4. Энэхүү дүрмийн 15 дугаар зүйлд заасан нөхцөл нь урьдчилсан тогтоолд нэгэн адил хамаарах бөгөөд энэхүү дүрмийн 15.1.1-д заасны дагуу тооцох хохирол нь уг тогтоолыг гаргах эсэхээс шалтгаалах хохирол байна.

Арван долоо. Урьдчилсан тогтоол гаргах тусгай журам

- 17.1. Бүрэлдэхүүн урьдчилсан тогтоол гаргуулах өргөдлийг шийдвэрлэсэн даруйдаа түр арга хэмжээ авах тухай хүсэлт, урьдчилсан тогтоол гаргуулах өргөдөл, урьдчилсан тогтоол гарсан бол уг тогтоолыг, үүнтэй холбоотойгоор Бүрэлдэхүүн аль нэг талтай амаар болон бусад хэлбэрээр харилцсан бүх мэдээллийг багтаасан мэдэгдлийг талуудад хүргүүлнэ.
- 17.2. Бүрэлдэхүүн энэхүү дүрмийн 18.1-д заасан мэдэгдлийг өгөхийн зэрэгцээ урьдчилсан тогтоолоор үүрэг хүлээсэн талд боломжит хамгийн богино хугацаа нь (20 хоногын дотор)-д тайлбараа гаргах боломж олгоно.
- 17.3. Урьдчилсан тогтоолыг эс зөвшөөрсөн тайлбарыг Бүрэлдэхүүн даруй хэлэлцэн шийдвэрлэнэ.
- 17.4. Бүрэлдэхүүний урьдчилсан тогтоол нь түүнийг гаргасан өдрөөс хойш 20 хоногийн дараа хүчингүй (допингийн улмаас түр түдгэлзүүлсэн тохиолдолд хамаарахгүй) болно. Урьдчилсан тогтоолыг холбогдох талд мэдэгдэж, тайлбар өгөх боломж олгосны дараа Бүрэлдэхүүн урьдчилсан тогтоолыг хэвээр үлдээх, эсхүл өөрчилж түр арга хэмжээ авах тухай шийдвэр гаргаж болно.
- 17.5. Талууд урьдчилсан тогтоолыг заавал биелүүлэх үүрэгтэй бөгөөд уг тогтоолыг шийдвэр гүйцэтгэлийн журмаар албадан гүйцэтгэхгүй.
- 17.6. Урьдчилсан тогтоол нь арбитрын үндсэн шийдвэрт хамаарахгүй.

**Арван найм. Түр арга хэмжээ, урьдчилсан тогтоолыг өөрчлөх,
түдгэлзүүлэх, дуусгавар болгох**

18.1. Бүрэлдэхүүн аль нэг талын өргөдлөөр, онцгой тохиолдолд талуудад мэдэгдсэний үндсэн дээр өмнө нь гаргасан шийдвэрийн биелэлт баталгаажуулах арга хэмжээ, эсхүл урьдчилсан тогтоолыг санаачилгаараа өөрчилж, түдгэлзүүлж, дуусгавар болгож болно.

Арван ес. Санхүүгийн баталгаа гаргуулах

19.1. Бүрэлдэхүүн нь түр арга хэмжээ авах тухай хүсэлт гаргасан талд уг арга хэмжээтэй холбогдуулан зохих санхүүгийн баталгаа гаргахыг шаардаж болно.

19.2. Бүрэлдэхүүн зохимжгүй, эсхүл шаардлагагүй гэж үзсэнээс бусад тохиолдолд урьдчилсан тогтоол гаргуулах тухай өргөдөл гаргасан талаас уг тогтоолтой холбогдуулан санхүүгийн баталгаа гаргахыг шаардана.

Хорь. Мэдээллийг ил болгох

20.1. Бүрэлдэхүүн түр арга хэмжээ авах хүсэлт гаргах, уг хүсэлтийг хангах үндэслэл болсон нөхцөл байдалд бодит өөрчлөлт гарсан тохиолдолд энэ талаар даруй мэдээлэхийг аль ч талаас шаардаж болно.

20.2. Урьдчилсан тогтоол гаргуулах тухай өргөдөл гаргасан тал уг тогтоолыг гаргах, эсхүл түүнд өөрчлөлт оруулах тухай шийдвэрт хамааралтай байж болох аливаа нөхцөл байдлыг Бүрэлдэхүүнд мэдээлэх үүрэгтэй бөгөөд энэхүү үүрэг нь нөгөө тал тайлбараа гаргах хүртэл хугацаанд хэвээр хадгалагдана.

Хорин нэг. Зардал, хохирлыг гаргуулах

21.1. Тухайн нөхцөл байдалд түр арга хэмжээ авах, урьдчилсан тогтоол гаргах шаардлагагүй байсныг Бүрэлдэхүүн хожим тогтоосон бол түүний улмаас аль нэг талын гаргасан зардал, учирсан хохирлыг уг түр арга хэмжээ авах тухай хүсэлт, урьдчилсан тогтоол гаргуулах тухай өргөдөл гаргасан тал хариуцна.

21.2. Бүрэлдэхүүн нь маргаан шийдвэрлэх ажиллагааны аль ч үед энэхүү дүрмийн 22.1-д заасан зардал, хохирлыг нөхөн төлүүлэх тухай шийдвэр гаргаж болно.

Хорин хоёр. Түр арга хэмжээг хүлээн зөвшөөрч, гүйцэтгэх

22.1. Бүрэлдэхүүнээс авсан түр арга хэмжээг талууд биелүүлэх үүрэгтэй бөгөөд тухайн шийдвэр эцсийнх байна.

22.2. Бүрэлдэхүүн өөрөөр тогтоогоогүй бол Арбитрын тухай хуулийн 28 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд, уг түр арга хэмжээ авах шийдвэрийг гүйцэтгүүлэхээр аль улсад гарснаас үл хамааран харьяалах шүүхэд өргөдөл гаргаж болно.

22.3. Түр арга хэмжээг хүлээн зөвшөөрч, гүйцэтгүүлэх өргөдөл гаргасан, эсхүл түүнд дурдсан хүсэлтээ хангуулсан тал нь тухайн арга хэмжээг өөрчилсөн, түдгэлзүүлсэн, цуцалсан тухай харьяалах шүүхэд даруй мэдэгдэх үүрэгтэй.

ТАВДУГААР БҮЛЭГ АРБИТРЫН АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ

Хорин гурав. Арбитрын ажиллагаа явуулах арга, хэлбэр

- 23.1. Арбитрын хуралдааныг талууд арбитрт итгэл үзүүлсэн бол нотлох баримт дээр түшиглэн талуудыг оролцуулахгүйгээр хуралдах, эсхүл талуудыг оролцуулан танхимын хэлбэрээр мэтгэлцэх хуралдаан, эсхүл цахим хуралдаан хэлбэрээр явуулж болно.
- 23.2. Хэргийн оролцогчид зөвшөөрсөн бол гэрч болон шинжээч, бусад оролцогчдоос урьдчилан мэдүүлэг авч болох бөгөөд мөн цахимаар оролцуулж болно.
- 23.3. Бүрэлдэхүүн талуудад эрх тэгш байдлаар хандаж, ажиллагааны зохих шат бүрийг шуурхай бөгөөд үр дүнтэй, ажил хэрэгч явуулахад бүхий л хүчин чармайлт гаргаж, шаардлагатай гэж үзсэн, талууд хүлээн зөвшөөрөхүйц арга, хэлбэрээр ажиллагааг явуулна. Үүнд дугуй ширээний зарчмаар буюу мэтгэлцэхдээ суудлаасаа заавал босохгүйгээр, бичиг баримтаа чөлөөтэй ашиглах боломжоор хангагдаж, онц шаардлагатай үед өмгөөлөгчтэйгөө болон нөгөө талтайгаа зөвшилцөх, эвлэрэх боломжоор хангагдана.
- 23.4. Бүрэлдэхүүн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бүрэлдэхүүнээс тогтоосон хугацаанд нь түргэн шуурхай явуулахын тулд талуудын саналыг харгалзан арбитрын хэлэлцээрт үл харшлах зохих процессын журам болон арбитрын ажиллагааны завсарын хуваарийг тогтоож, харилцан тохиролцсон хугацааг сунгах эсхүл богиносгож болно.
- 23.5. Бүрэлдэхүүн ажиллагааны үр дүнтэй байдлыг хангахын тулд талуудын саналыг харгалзан арбитрын хэлэлцээрт үл харшлах зохих процессын журам болон арбитрын ажиллагааны завсарын хуваарийг тогтоож, харилцан тохиролцсон хугацааг сунгах эсхүл богиносгож болно.
- 23.6. Талууд Бүрэлдэхүүнтэй харилцах аливаа харилцаа холбоог нарийн бичиг болон нөгөө талдаа заавал мэдэгдэх бөгөөд ийм харилцаа холбоог тэдгээрийг оролцуулан нэг цаг хугацаанд, хамтран явуулна. Аль нэг тал арбитрчтай ганцаарчилсан харилцаа холбоо тогтоох, уулзалт хийхийг хориглоно.
- 23.7. Хэрвээ хуралдааныг гадаад хэл дээр явуулах бол орчуулагч, хэлмэрч боломжтой бол спортын орчуулагч оролцуулна. Орчуулагч нь мэргэжлийн диплом, үнэмлэх, зөвшөөрөлтэй байхаас гадна хөндлөнгийн байх зарчмаар сонгогдсон байна.
- 23.8. Бүрэлдэхүүн хэргийн оролцогчдын тайлбарыг сонссоны дараа нэмэлт материал цуглуулах шаардлагатай гэж үзвэл ажиллагааны аль ч үед гэрчээс мэдүүлэг авч, шинжээчийн дүгнэлтийг сонсож мөн хэргийн үнэн зөвийг тогтооход шаардлагатай гэж үзсэнбусад арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Хорин дөрөв. Арбитрын ажиллагаа явуулах журмыг тодорхойлох

- 24.1. Талууд өөрөөр харилцан тохиролцоогүй бол Бүрэлдэхүүн талуудын саналыг авч арбитрын үндсэн хуралдааны журмыг тодорхойлох урьдчилсан хуралдааныг зохион байгуулна.
- 24.2. Арбитрын ажиллагааны журамд дараах зүйлийг тусгана. Үүнд:
 - 24.2.1.Талуудын албан ёсны нэр, хаяг
 - 24.2.2.Арбитрын хэлэлцээр, түүний хүчин төгөлдөр эсэх талаар
 - 24.2.3. Арбитрын харьяалал

- 24.2.4. Маргааны агуулга, нэхэмжлэлийн шаардлага
 - 24.2.5. Хариу тайлбар
 - 24.2.6. Арбитрын хураамж, зардал
 - 24.2.7. Тогтоох ёстой бусад асуудлууд
 - 24.2.8. Арбитрын ажиллагаа явуулах газар
 - 24.2.9. Арбитрын ажиллагаа явуулах хэл, бичиг
 - 24.2.10. Арбитрын ажиллагаанд хэрэглэх эрх зүй
 - 24.2.11. Арбитрын хуралдааныг хэрхэн явуулах эсэх
- 24.3. Арбитрын ажиллагааны журамд талууд болон Бүрэлдэхүүн гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд хэлбэрлэлтгүй сахина.
- 24.4. Бүрэлдэхүүн даргалагч нь арбитрын ажиллагаа болон хуралдааныг удирдана.
- 24.5. Талууд, эсхүл Бүрэлдэхүүн санал нэгтэй зөвшөөрсөн бол арбитрын ажиллагааны явцад гарах арбитрын шийдвэр гаргах, шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулах, тайлбарлах, нэмэлт шийдвэр гаргах, арбитрын ажиллагааны журмыг тодорхойлох, арбитрчийг татгалзан гаргах, нөхөн томилохоос бусад асуудлаар, тухайлбал арбитрын ажиллагааны явцад гарах горимын шинжтэй асуудлыг Бүрэлдэхүүн даргалагч дангаараа шийдвэрлэж болно.

Хорин тав. Арбитрын ажиллагаа болон хуралдаан хийх газар

- 25.1. Спортын арбитрын ажиллагаа явуулах газар болон хуралдаан хийх газар нь Монгол Улсын Улаанбаатар хот байна.
- 25.2. Бүрэлдэхүүн хэрэг, маргааныг зөв, шуурхай, бусдад чирэгдэл багатай, маргаан үүссэн нутаг дэвсгэрийн орон зай, зам тээврийн нөхцөл, гарах зардал зэргийг харгалзан арбитрын хуралдаан хийх газрыг талуудын саналыг харгалзан өөр газарт явуулах шийдвэр гаргаж болно.
- 25.3. Бүрэлдэхүүн гэрч, шинжээч, талуудын мэдүүлгийг сонсох, бараа бүтээгдэхүүн, эд хөрөнгө, баримт бичигт үзлэг, шалгалт хийх зэрэг ажиллагааг арбитрын ажиллагаа өөр газарт явуулах шийдвэр гаргаж болно.

Хорин зургаа. Арбитрын ажиллагааны хэл, бичиг

- 26.1. Арбитрын ажиллагаа явуулах хэл нь Монгол хэл байна. Арбитрын ажиллагааны албан ёсны бичиг нь Төрийн албан ёсны хэлний тухай хуулийн заалт шаардлагыг хангасан байна.
- 26.2. Талууд явуулах хэл, бичгийг тохиролцож өөрөөр тогтоож болно. Хэрэв талууд энэ талаар тохиролцоогүй бол Бүрэлдэхүүн хэрэглэх эрх зүй, маргааны агуулга, талууд аль улсын харьяат болох, тэдний сайн мэдэх хэл, бичиг зэргийг үндэслэн ажиллагааны хэл, бичгийг тогтооно.
- 26.3. Талууд эсхүл Бүрэлдэхүүн тогтоосон хэл, бичгийг арбитрын бүхий л ажиллагаанд хэрэглэнэ.
- 26.4. Арбитрын ажиллагааны явцад тогтоосон хэл, бичгээс өөр хэл, бичгээр үйлдэгдсэн аливаа бичгэн нотлох баримтыг тогтоосон хэл рүү орчуулахыг Бүрэлдэхүүн талуудаас шаардана.

- 26.5. Бичгэн орчуулга нь орчуулга хийх эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажсан, талууд хүсвэл нотариатаар гэрчлүүлсэн байж болно.
- 26.6. Талууд монгол хэл, бичиг мэдэхгүй бол Арбитрын ажиллагаанд гадаад хэлний орчуулагч, хэлгүй, дүлий гэх мэт хөгжлийн бэрхшээлтэй, бичиг үсэг мэдэхгүй бол хэлмэрч оролцуулж болох бөгөөд энэхүү хэлмэрчлэл болон орчуулгын үнэн зөв болон зардлыг талууд өөрсдөө хариуцна.
- 26.7. Бүрэлдэхүүн шаардлагатай тохиолдолд талуудаас үл хамаарах хөндлөнгийн орчуулагч, хэлмэрч томилж болно. Хөндлөнгийн хэлмэрч, орчуулагч тусгай тэмдэгт, дохио зангаа ашигласан бол хэрэгт авч баталгаажуулах бөгөөд зардлыг талуудаас гаргуулна.
- 26.8. Талууд өөр өөр хэлээр харилцдаг бол Бүрэлдэхүүн тэдний сайн мэдэх хэл дээр, ийм боломжгүй бол тус бүрийн орчуулагчийг оролцуулах журмаар төрөлх буюу сайн мэдэх хэл дээрээ тайлбар хийх, хуралдаанд оролцох, үг хэлэх боломжоор хангана.
- 26.9. Бүрэлдэхүүнд хэд хэдэн улсын арбитрчид орсон нөхцөлд зөвхөн арбитрч нарын бие даасан орчуулагч оролцуулах бөгөөд түүнээс нууц хадгалах баталгаа гаргуулан авч зөвлөлдөх тасалгаанд орчуулагчийн тусламжийг авч болно.
- 26.10. Бүрэлдэхүүн томилогдоогүй бол Ажлын албаны дарга арбитрын ажиллагааны хэлнээс өөр хэл дээр ирүүлсэн бүх баримт бичгийг ажиллагааны хэл дээрх баталгаат орчуулгын хамт ирүүлэхийг шаардаж болно.

Хорин долоо. Талуудын эрх, үүрэг ба тэгш байдал

- 27.1. Талууд арбитрын ажиллагаанд тэгш эрхтэй оролцох бөгөөд өөрсдийн байр суурийг чөлөөтэй, хөндлөнгийн нөлөөллөөс ангид нөхцөлд илэрхийлэх боломжоор бүрэн хангагдсан байх зарчмыг баримтална.
- 27.2. Талууд арбитрын ажиллагааны явцад тайлбар, хүсэлт гаргах, үг хэлэх, нотлох баримт гаргах, мэтгэлцэх эрхээ адил хэлбэр, хугацаа, удаа дарааллаар тэгш эдлэх боломжоор бүрэн дүүрэн хангагдсан байна. Харин энэхүү эрхээ эдлээгүй явдал тухайн оролцогчийн хувийн асуудал бөгөөд эрхээ эдлэлгүй дараагийн ажиллагаанд оролцоод явсан бол уг эрхээ эдэлсэнтэй адилтган тооцно.
- 27.3. Арбитрын ажиллагаанд оролцогч талууд нь дараах эрхийг эдэлнэ.
- 27.3.1. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үед хэргийн материалтай танилцах, хуулбарлан авах, тэмдэглэл үйлдэх, арбитрын хуралдааны үед даргалагч арбитрчийн зөвшөөрлөөр бусад оролцогчдод асуулт тавих, хариулт авах
- 27.3.2. Шинжээч томилуулах, үзлэг явуулах, гэрч асуулгах, хэлмэрч, орчуулагч оролцуулах тухай хүсэлт гаргах
- 27.3.3. Бүрэлдэхүүн, арбитрч, шинжээч, орчуулагч, гэрч, хэлмэрч бусад этгээдийг татгалзах
- 27.3.4. Нэхэмжлэгч нь нэхэмжлэл гаргасан үндэслэл буюу нэхэмжлэлийг өөрчлөх, нэхэмжлэлийн шаардлагын хэмжээг ихэсгэх буюу багасгах, эсхүл нэхэмжлэлээс бүр мөсөн татгалзах, эвлэрэн хэлэлцэх
- 27.3.5. Хариуцагч нь нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрөх, татгалзах, сөрөг нэхэмжлэл гаргах, эвлэрэн хэлэлцэх
- 27.3.6. Хуульд заасан үндэслэл болон хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хурал

хойшлуулах хүсэлт гаргах

- 27.4. Арбитрын ажиллагаанд оролцогч талууд нь дараах үүргийг хүлээнэ.
- 27.4.1. Нэхэмжлэл болон татгалзлын үндэслэл болох нөхцөл байдлыг нотлох.
 - 27.4.2. Бүрэлдэхүүн болон нарийн бичгийн даргаас тавьсан шаардлагыг биелүүлэх
 - 27.4.3. Бүрэлдэхүүний гаргасан шийдвэрийг хүндэтгэн биелүүлэх
 - 27.4.4. Арбитрын нарийн бичгийн даргаас дуудсан хугацаанд болон арбитрын хуралдаанд хүрэлцэн ирнэ.
 - 27.4.5. Арбитрын хавтаст хэрэгт гаргаж өгсөн нэхэмжлэл болон бусад бичиг баримтын хуулбарыг нөгөө талд илгээх
 - 27.4.6. Нууц хамгаалах мэдэгдлийг биелүүлэх.
- 27.5. Талууд иргэн бол арбитрын ажиллагаанд төлөөлөгч оролцуулахдаа эдлэх эрх, үүргийг нь тодорхойлсон, нотариатаар баталгаажуулсан итгэмжлэлийг арбитрт ирүүлнэ. Харин талууд хуулийн этгээд бол албан бичгээр итгэмжлэл олгож болно.
- 27.6. Итгэмжлэл Монгол улсын Иргэний хуулийн 64 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангах бөгөөд нэмэлтээр электрон шуудангийн хаяг, харилцах утасны дугаарыг тусгасан байна.
- 27.7. Өмгөөлөгч оролцох бол гэрээ хийгдсэн байна. Талууд болон тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч арбитрын ажиллагааны тухай мэдэгдлийн дагуу оролцоогүй, арбитрын хуралдаанд ирээгүй, эсхүл хуралдааны явцад хурлыг орхин гарсан нөхцөлд, нөгөө талын саналыг харгалзан хуралдааныг хойшлуулах, эсхүл хуралдааныг ердийн журмаар үргэлжлүүлнэ.

Хорин найм. Гуравдагч этгээд

- 28.1. Талуудын хүсэлтээр эсхүл гуравдагч этгээд өөрөө арбитрын ажиллагаанд оролцох тухай хүсэлт гаргаж болох бөгөөд хүсэлтээ нотлох холбогдох баримт бичгийг хавсаргана.
- 28.2. Бүрэлдэхүүн гуравдагч этгээдтэй холбоотой хүсэлт, түүнд хавсаргасан холбогдох материалыг талуудад танилцуулж, тайлбар гаргах хугацааг тогтооно.
- 28.3. Талуудын хүсэлтээр эсхүл гуравдагч этгээдийн өөрийн хүсэлтээр арбитрын ажиллагаанд гуравдагч этгээдээр оролцуулах, оролцох бол Спортын арбитрын зардлын журмаар тогтоосон хэмжээгээр зардлыг хүсэлт гаргасан тал төлнө.
- 28.4. Бүрэлдэхүүн хэргийг бодитой, бүрэн дүүрэн шийдвэрлэхэд шаардлагатай гэж үзэн өөрийн санаачилгаар гуравдагч этгээдийг оролцуулсан тохиолдолд тухайн гуравдагч этгээдийг Спортын арбитрын зардлын журамд заасан зардлаас чөлөөлнө.
- 28.5. Гуравдагч этгээдийг оролцуулах эсэхийг Бүрэлдэхүүн эцэслэн шийдвэрлэх бөгөөд шийдвэр нь эцсийнх байна.

Хорин ес. Нотлох баримт гаргах ба цуглуулах

- 29.1. Арбитрын хэргийн нотлох баримт нь талууд, тэдгээрийн төлөөлөгч, гуравдагч этгээдийн тайлбар, гэрчийн мэдүүлэг, бичмэл /гэрээ хэлэлцээр, дүрэм журам, протокол, тодорхойлолт, төлбөрийн даалгавар, тооцооны баримт, тооцоо нийлсэн акт,

хилээр нэвтрүүлэх барааны гаалийн мэдүүлэг, чанарын сертификат гэх мэт/ болон электрон хэлбэр дэх баримтууд, шинжээчийн дүгнэлт, мэргэжлийн байгууллага болон мэргэжилтний дүгнэлт, эд мөрийн баримт, туршилт, үзлэгийн тэмдэглэл зэргээс бүрдэнэ. Нотлох баримтыг талууд арбитрт гаргаж өгөх үүрэгтэй.

- 29.2. Арбитрын нарийн бичиг нь хэргийг хянан шийдвэрлэх бэлтгэл ажиллагааны явц байдлыг Бүрэлдэхүүн\даргалагч\ -д утсаар болон биечлэн танилцуулах бөгөөд зарим даалгаврыг арбитрч нь нарийн бичигт өгч гүйцэтгүүлнэ.
- 29.3. Бүрэлдэхүүн шаардлагатай бол талуудаас нэмэлт нотлох баримт шаардах бөгөөд эдгээрийг арбитрт ирүүлэх хугацааг тогтооно.
- 29.4. Нотлох баримтыг тухайн хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, үнэн зөв, эргэлзээгүй талаас харьцуулах, жиших аргачлалаар үнэлэх нь Бүрэлдэхүүний бүрэн эрхэд хамаарна.
- 29.5. Талууд тэдгээрийн төлөөлөгч, гуравдагч этгээд нь өөрийн шаардлага, татгалзлын үндэслэл болж байгаа нөхцөл байдлыг өөрөө нотлох үүрэгтэй.
- 29.6. Талууд, тэдгээрийн төлөөлөгч, гуравдагч этгээд нь хуурамч нотлох баримт гаргах буюу хууль бус аргаар цуглуулахыг хориглоно. Ийм арга хэлбэрээр гаргасан нотлох баримт нь нотлох чанараа алдах бөгөөд арбитрын шийдвэрийн үндэслэл болохгүй.
- 29.7. Нотлох баримтыг арбитрын хуралдаан эхлэхээс өмнө 7 (долоо)-гоос доошгүй хоногийн өмнө арбитрт ирүүлэх бөгөөд хэрэв энэхүү хугацаа хэтэрвэл нотлох баримтыг хүлээж авах эсэхийг Бүрэлдэхүүн шийдвэрлэнэ.
- 29.8. Арбитрын хуралдааны үед шинэ нотлох баримт бүрдүүлэх шаардлагатай гэж үзвэл Бүрэлдэхүүн арбитрын хуралдааныг хойшлуулж болно.
- 29.9. Нотлох баримт бүрдүүлэхэд шүүх болон бусад байгууллага туслалцаа үзүүлнэ.

Гуч. Хэргийн бодит нөхцөл байдлыг тогтоох

- 30.1. Бүрэлдэхүүн маргааны бодит байдлыг тогтооно. Ийнхүү тогтоохдоо Бүрэлдэхүүн гэрч дуудах, шинжээч томилох, үзлэг хийх болон баримт бичиг нэмж гаргуулах, хуулиар зөвшөөрсөн бусад ажиллагаа- /туршилт хийх, даалгавар бичих г.м /-г хийнэ.
- 30.2. Шаардлагатай бол талуудын хүсэлт болон Бүрэлдэхүүнээс шинжээчийн дүгнэлт гаргуулахаар нарийн мэргэжлийн, хөндлөнгийн шинжээч томилно.
- 30.3. Шинжээч нь зарчмын хувьд тухайн томилгоог хүлээн авахын өмнө Бүрэлдэхүүнд өөрийн мэргэшил болон бие даасан, талуудаас хараат бус байдлын талаарх мэдэгдлийг ирүүлнэ.
- 30.4. Шинжээч нь шаардлагатай гэж үзвэл тухайн хэргийн материалтай танилцах, нэмэлт материал гаргаж өгөхийг арбитраас болон талуудаас шаардах, үзлэг хийх эрхтэй.
- 30.5. Арбитрын шийдвэр гаргахад ашиглаж буй шинжээчийн дүгнэлт, нотолгооны шинжтэй бусад баримт бичгийг Бүрэлдэхүүн талуудад мөн нэг адил хүргүүлнэ.
- 30.6. Шинжээч дүгнэлтийг шударгаар гаргах нь эргэлзээтэй гэж үзвэл талууд түүнээс татгалзаж болно. Ийнхүү татгалзан гарах асуудлыг Бүрэлдэхүүн шийдвэрлэнэ.
- 30.7. Аль нэг шинжээч нь бусад шинжээчийн дүгнэлттэй санал нийлэхгүй байвал дүгнэлт, тайлбараа тусад нь гаргаж болно.
- 30.8. Бүрэлдэхүүн хэргийг хянан шийдвэрлэх, шинжээч дүгнэлт гаргахдаа зарим байдлыг тодруулахын тулд бараа эд зүйлс, баримт бичигт үзлэг хийж болно.

- 30.9. Үзлэгийг хэргийн оролцогчдыг оролцуулан хийж, тэмдэглэл үйлдэнэ. Хэргийн оролцогчид ирээгүй явдал нь үзлэг хийхэд саад болохгүй.
- 30.10. Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулан бусдаас нарийн мэргэжлийн тусламж авч болно. Үүнд маргаантай шийдвэрийг гаргасан холбоо, нийгэмлэг болон спорттой холбоотой байгууллагуудаас санал авах ажиллагаа хамаарна.
- 30.11. Талууд Бүрэлдэхүүний шаардсан бичиг баримт, бодит нотлох баримт болон бусад нотлох баримтыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр, тогтсон хугацаанд гаргаж өгөөгүй бол Бүрэлдэхүүн хэрэгт цугларсан нотлох баримтын хүрээнд шийдвэр гаргаж болно.
- 30.12. Бүрэлдэхүүн болон талууд арбитрын хуралдаанд гэрч оролцуулж болно, эсхүл гэрчээс урьдчилан мэдүүлэг авч болно.
- 30.13. Хэргийн оролцогчид, гэрч нарыг хуралдаанд ирэхийг мэдэгдсэн боловч хүрэлцэн ирээгүй байсан ч хуралдааныг явуулан, арбитрын шийдвэрийг гаргана.

Гучин нэг. Тэмдэглэл

- 31.1. Арбитрын хуралдааны тэмдэглэлийг аудио эсхүл видео (аудио-дүрс) хэлбэрээр хадгална. Арбитрын үндсэн хуралдааныг тэмдэглэлийг бичгээр гаргаж хадгална.
- 31.2. Талуудад хуралдааны аудио эсхүл видео (аудио-дүрс) бичлэгийг хуулбарлаж өгөхгүй бөгөөд арбитрын хуралдааны тэмдэглэлийг бичгээр гаргуулан танилцахаар бол Спортын арбитрын зардлын журмаар тогтоосон зардлыг төлнө.
- 31.3. Арбитрын үндсэн хуралдааны тэмдэглэлийг талуудад танилцуулна.
- 31.4.** Спортын арбитрын Ерөнхий нарийн бичгийн дарга нь хуралдааны аудио, эсхүл видео (аудио-дүрс) бичлэгийг журмын дагуу хадгална.
- 31.5. Тэмдэглэлийг нарийн бичгийн дарга хөтлөж, Бүрэлдэхүүн даргалагч баталгаажуулна.

Гучин хоёр. Талууд үүргээ биелүүлэхгүй байх, үүсэх үр дагавар

- 32.1. Нэхэмжлэгч шаардлагаа тодорхойлоогүй, мөнгөн дүнгээр илэрхийлээгүй, нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл болох үйл баримтад холбогдох нотлох баримтаар дэмжээгүй эсхүл ирүүлээгүй, энэ талаар тогтоосон хугацаа дууссан бол Бүрэлдэхүүн арбитрын ажиллагааг дуусгавар болгох тухай шийдвэр гаргаж болно.
- 32.2. Хариуцагч тогтоосон хугацаанд ирүүлээгүй бол Бүрэлдэхүүн арбитрын маргаан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэн явуулна.
- 32.3. Талууд арбитрын ажиллагааны талаар болон хуралдааны товыг албан ёсоор хүлээн авсан боловч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоогүй, эсхүл тогтоосон хугацаанд нотлох баримтаа гаргаж өгөөгүй бол Бүрэлдэхүүн ажиллагааг үргэлжлүүлж, цугларсан нотлох баримтад үндэслэн шийдвэр гаргана.

Гучин гурав. Арбитрын урьдчилсан хуралдаан

- 33.1. Арбитрын тухай Монгол Улсын хуулийн 52 дугаар зүйлийн 52.4-д заасны дагуу маргаанаа Спортын арбитраар шийдвэрлүүлэхээр талууд бие даасан арбитрын

хэлэлцээр хийсэн, эсхүл хэлэлцээрийн заалттай, эсхүл спортын арга хэмжээний гэрээндээ тусгасан, мөн маргаан үүссэний дараа тохиролцсон, түүнчлэн аль нэг тал Спортын арбитраар шийдвэрлэхийг эсэргүүцээгүй, хүлээн зөвшөөрсөн үйлдэл хийсэн бол арбитраын хэлэлцээртэй адилтган үзнэ.

33.2. Спортын маргааныг арбитраын байгууллагаар шийдвэрлүүлэхийн тулд дараах нөхцөлийг бичгээр илэрхийлсэн байна:

33.1.1. Аливаа спортын холбоо, ниймгэмлэг, клуб болон спортыг зохион байгуулах үйл ажиллагааны гэрээнд “Маргааныг Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитраар шийдвэрлүүлнэ” гэж тусгасан байх

33.1.2. Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитраын бие даасан тусгай хэлэлцээр хийсэн байх /загвар гэрээг хавсаргав/.

33.1.3. Маргаан үүссэний дараа мэтгэлцэгч талууд маргаанаа Спортын арбитраар шийдвэрлүүлэхээр тохиролцсон,

33.1.4. Арбитрт хэлэлцээргүй ч арбитрт шууд хандах, нөгөө тал үүнийг нь эсэргүүцээгүй, хүлээн зөвшөөрсөн, хариу тайлбар, нотлох баримт гаргаж мэтгэлцсэн нөхцөлд арбитраын хэлэлцээр хийсэнтэй адилтган үзэх,

33.3. Бүрэлдэхүүн маргааныг арбитраын харьяаллын маргаан мөн эсэхийг тогтоох бөгөөд талууд арбитраын хэлэлцээртэй эсэх, тухайн хэлэлцээр хүчин төгөлдөр эсэхийг шийдвэрлэнэ.

33.4. Гэрээний арбитраын заалтыг гэрээний бусад нөхцөл хүчинтэй эсэхээс үл хамаарч бие даасан, арбитраын хэлэлцээртэй, хүчин төгөлдөр гэж үзнэ.

33.5. Талууд харьяаллын талаар гомдол гаргахаар бол нэхэмжлэлд тайлбар гаргахаасаа өмнө тус Бүрэлдэхүүнд гаргана. Нэхэмжлэлийг хүлээн авсан, арбитрч сонгосон, харьяаллынталаар тайлбар гаргасан, урьдчилсан хуралдаанд оролцсон нь арбитраын хэлэлцээр болон харьяаллыг хүлээн зөвшөөрсөн гэж үзэх үндэслэл болохгүй.

33.6. Шүүх, бусад эрх бүхий байгууллага шийдвэрлэхээр хуулиар тусгайлан харьяалал тогтоосон аливаа хэрэг, маргаанаас бусад зөвхөн спорттой холбоо бүхий, Арбитраын тухай хууль болон хэлэлцээрт тусгайлан заасан спортын маргааныг тус арбитрт харьяалан хянаж шийдвэрлэнэ.

Гучин дөрөв. Арбитраын үндсэн хуралдаан

34.1. Арбитраын хуралдаанд талуудыг оролцуулж хийх, эсхүл оролцуулахгүйгээр хийх гэсэн хоёр хэлбэрээр зохион байгуулж болно. Талууд арбитраын хуралдаанд биечлэн оролцохгүй, Бүрэлдэхүүнд итгэл үзүүлэн маргааныг цугларсан нотлох баримтад үндэслэн шийдвэрлүүлэх хүсэлт гаргавал Бүрэлдэхүүн хэрэгт авагдсан нотлох баримтын үндсэн дээр хэргийг зөвлөлдөх журмаар шийдвэрлэж болно.

34.2. Талууд арбитраын хуралдаанд оролцохоор тохиролцсон, эсхүл аль нэг тал ийнхүү хүсэлт гаргасан бол Бүрэлдэхүүн талуудыг оролцуулан арбитраын хуралдааныг мэтгэлцэх зарчмаар явуулж хэргийг шийдвэрлэнэ.

34.3. Арбитраын хуралдаан болох газар, огноог талуудад урьдчилан /харилцаа холбооны бүх боломжит хувилбараар/ мэдэгдэнэ.

34.4. Бүрэлдэхүүн хэрэг хянан шийдвэрлэхдээ хэргийн талаар авагдсан нотлох баримтыг бүх талаас нь шинжлэн судалж, хэргийн оролцогчдын шаардлага, тайлбарыг сонсож,

талуудыг тайлбар хийх адил боломжоор хангалттай хангагдсан гэж үзсэн тохиолдолд зөвлөлдөхөөр арбитрын хуралдааныг завсарлана.

- 34.5. Арбитрын хуралдаан завсарласнаар Бүрэлдэхүүн тусгайлан зөвлөлдөх бөгөөд зайлшгүй шаардлагатай гэж үзвэл өөрийн санаачилгаар арбитрын шийдвэр гаргахаас өмнө хуралдааныг дахин үргэлжлүүлэх эсхүл хойшлуулж болно.
- 34.6. Арбитрчид тусгайлан зөвлөлдөхдөө хаалттай хийх ба зөвлөлдөх тасалгааны нууцыг чандлан хадгална.
- 34.7. Бүрэлдэхүүн зөвлөлдөж олонхийн саналаар шийдвэрээ гаргах бөгөөд зөвлөлдөх хугацааг хязгаарлахгүй, Бүрэлдэхүүн шийдвэрийн агуулгыг танилцуулж хуралдааныг хаана.

Гучин тав. Талууд эвлэрэх

- 35.1. Арбитрын ажиллагааны явцад болон Бүрэлдэхүүн зөвлөлдөхөөс өмнө талууд маргааны талаар эвлэрэн хэлэлцэж болно.
- 35.2. Бүрэлдэхүүн шийдвэр гарахаас өмнө талууд эвлэрэхээр санал нэгдсэн бол Бүрэлдэхүүн арбитрын ажиллагааг дуусгавар болгох тухай шийдвэр гаргах, эсхүл талууд эвлэрэн хэлэлцсэнээ арбитрын шийдвэрт тусгуулах хүсэлт гаргавал Бүрэлдэхүүн татгалзаагүй бол эвлэрлийн нөхцөлийг арбитрын шийдвэрт тусгаж баталгаажуулна. Шийдвэрт түүнийг гаргасан үндэслэлийг заахгүй байж болно.
- 35.3. Эвлэрлийн гэрээг баталгаажуулсан шийдвэр нь Бүрэлдэхүүн хэрэг хянан шийдвэрлэсэн тухай шийдвэрийн адил хүчинтэй.
- 35.4. Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад талууд эвлэрүүлэн зуучлалын журмаар эвлэрэн хэлэлцэх хүсэлт гаргавал Бүрэлдэхүүн мэргэшсэн эвлэрүүлэн зуучлагчид хандах боломжийг талуудад хуульд заасан хугацаагаар олгоно.

Гучин зургаа. Арбитрын шийдвэрүүд

- 36.1. Бүрэлдэхүүнд нэгээс илүү арбитрч оролцож байгаа тохиолдолд шийдвэрүүдийг олонхийн саналаар гаргана.
- 36.2. Арбитр шийдвэрийг бичгээр гаргаж, Бүрэлдэхүүн гарын үсэг зурна. Нэгээс илүү арбитрч оролцсон Бүрэлдэхүүний гаргасан шийдвэрт тэдгээрийн олонхи гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болох ба аль нэг арбитрч гарын үсэг зураагүй бол шалтгааныг нь заана.
- 36.3. Арбитрын шийдвэрийг талууд заавал дагаж мөрдөж, тогтоосон хугацаанд нь биелүүлэх үүрэгтэй.
- 36.4. Бүрэлдэхүүн зөвлөлдөөд гаргасан шийдвэрийнхээ агуулгыг талуудад танилцуулах бөгөөд ийнхүү танилцуулахад талууд байлцахгүй байж болно. Арбитрын шийдвэрийг агуулгыг танилцуулсан өдрөөс хойш 14 хоногийн дотор бичгээр үйлдэж, ёсчилсон буюу албажуулсан байна.
- 36.5. Талууд үндсэн шийдвэрийн үндэслэлийг заах шаардлагагүй гэж тохиролцсон, эсхүл талууд эвлэрснээс бусад тохиолдолд арбитрын үндсэн шийдвэрт түүнийг гаргах болсон үндэслэлийг тодорхой заана.
- 36.6. Арбитрын шийдвэрийн дүгнэлтийн болон тогтоох хэсгийг Бүрэлдэхүүн даргалагч

үйлдэж, Ажлын алба бусад хэсгийг нэгтгэн, бусад арбитрч нарын саналыг авч, алдааг хянаж, гарын үсэг зуруулах, тамга, тэмдэг дарах, дугаар өгөх ажиллагааг гүйцэтгэнэ.

- 36.7. Арбитрын шийдвэр гаргасан огноог арбитрын хуралдаан явуулсан тохиолдолд шийдвэрийн агуулгыг танилцуулсан өдөр, харин Арбитрын хуралдаан явуулалгүй шийдвэргаргасан тохиолдолд арбитрчид шийдвэрт гарын үсэг зурсан өдөр байна.
- 36.8. Бүрэлдэхүүн арбитрын шийдвэрийн эх хувийг хэрэгт, зохигчид, оролцогсодын зохих тоогоор үйлдэнэ. Ажлын алба шийдвэрийн нэг хувийг хавтаст хэрэгт хадгалж, бусад эх хувийг талуудад нэн даруй гардуулах буюу хүргүүлнэ.
- 36.9. Арбитрын ажиллагааны явцад гарсан нэмэлт зардлыг талууд бүрэн төлөх хүртэл арбитрын шийдвэрийг талуудад хүргүүлэх ажиллагааг хойшлуулж болно.

Гучин долоо. Арбитрын ажиллагааг дуусгавар болгох

- 37.1. Арбитрын ажиллагааг дуусгавар болгохдоо Арбитрын тухай хуулийн 45 дугаар зүйлд заасныг баримтална. Мөн доорх үндэслэлээр арбитрын ажиллагааг дуусгавар болгоно.
 - 37.1.1. арбитрын харьяаллын маргаан биш болох нь тогтоогдсон;
 - 37.1.2. нэхэмжлэлээсээ татгалзсан. Ийнхүү татгалзсаныг хариуцагч зөвшөөрөөгүй бөгөөд Бүрэлдэхүүн маргааныг эцэслэн шийдвэрлүүлэх хариуцагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хүлээн зөвшөөрсөн бол энэ заалт хамаарахгүй;
 - 37.1.3. талууд эвлэрсэн, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн, шийдвэр гарахаас өмнө сайн дураар биелүүлсэн, нэхэмжлэлээ татан авсан;
 - 37.1.4. талууд арбитрын ажиллагааг дуусгавар болгохоор тохиролцсон;
 - 37.1.5. талууд арбитрын зардлыг тогтоосон хугацаанд төлөөгүй;
 - 37.1.6. Бүрэлдэхүүн дээр дурдсанаас бусад шалтгаанаар буюу талууд Бүрэлдэхүүний шаардлагыг биелүүлээгүй, арбитрын ажиллагаанд оролцоогүй, идэвхигүй оролцсон, эсхүл арбитрын ажиллагааг үргэлжлүүлэх боломжгүй болсон, эсхүл шаардлагагүй болсон гэж үзсэн;
- 37.2. Арбитрын шийдвэрт засвар оруулах, тайлбарлах, нэмэлт шийдвэр гаргахдаа Арбитрын тухай хуулийн 46 дугаар зүйлийг баримтална.
- 37.3. Бүрэлдэхүүн шийдвэрт засвар оруулах, тайлбарлах, нэмэлт шийдвэр гаргах үндэслэлгүй гэж үзвэл энэ тухайгаа талуудад бичгээр мэдэгдэнэ.

Гучин найм. Арбитрын шийдвэрийг биелүүлэх

- 38.1. Арбитрын шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болмогц заавал биелэгдэх ёстой бөгөөд талууд шийдвэрийг хүндэтгэн биелүүлэх үүрэгтэй.
- 38.2. Арбитрын шийдвэр нь тус улсын нутаг дэвсгэрт, түүнчлэн гадаад улсад нэгэн адил хүчин төгөлдөр гүйцэтгэгдэнэ.

Гучин ес. Арбитрын ажиллагааг түргэвчилсэн хэлбэрээр явуулах журам

- 39.1. Талууд арбитрын ажиллагааг түргэвчилсэн хэлбэрээр явуулахаар тохиролцож болно.
- 39.2. Талууд өөрөөр тохиролцоогүй бол дараах төрлийн маргааныг түргэвчилсэн

хэлбэрээр хянан шийдвэрлэнэ:

- 39.2.1. тамирчин, дасгалжуулагч, шүүгч, спортын тэмцээн, бэлтгэл, сонгон шалгаруулалт, бүртгэл, лиценз болон спортын үйл ажиллагаанд оролцох эрхийг сэргээхтэй холбоотой маргаан;
- 39.2.2. тамирчин, дасгалжуулагч, шүүгч болон спортын байгууллагын ажилтан, албан тушаалтны цалин, хөлс, шагнал, урамшуулал, нөхөн олговор болон хөдөлмөр, үйлчилгээний гэрээний төлбөртэй холбоотой маргаан;
- 39.2.3. тэмцээн, уралдаан, сонгон шалгаруулалт, олон улсын тэмцээнд оролцох эрхтэй холбоотой бөгөөд тодорхой хугацаанаас өмнө шийдвэрлэх шаардлагатай маргаан;
- 39.2.4. спортын арга хэмжээ эхлэхээс өмнө яаралтай шийдвэрлэх шаардлагатай бөгөөд энгийн журмаар шийдвэрлэх нь талуудын эрх, хууль ёсны ашиг сонирхолд ноцтой хохирол учруулах эрсдэлтэй гэж үзсэн бусад маргаан.
- 39.2.5. хууль болон энэхүү дүрэмд түргэвчилсэн журмаар шийдвэрлэхээр тусгайлан заасан бусад маргаан.
- 39.3. Арбитрын ажиллагааг түргэвчилсэн хэлбэрээр явуулахаар бол маргаан шийдвэрлэх Бүрэлдэхүүн нэг арбитрчаас бүрдэх бөгөөд тухайн арбитрчийг Ерөнхийлөгч томилно.
- 39.4. Арбитрч хэргийн материал хүлээн авсан даруйд арбитрын ажиллагаа явуулах журмыг тодорхойлоход зайлшгүй шаардлагатай энэхүү дүрмийн 24 дугаар зүйлийн 24.2-д заасан асуудлаар өөрсдийн саналыг 7 хоногийн дотор бичгээр ирүүлэхийг талуудаас шаардана.
- 39.5. Арбитрч арбитрын ажиллагааг явуулах журмыг талуудын урьдчилан бичгээр ирүүлсэн саналын үндсэн дээр тодорхойлох бөгөөд хэрэв талууд санал зөрвөл арбитрч өөрөө тодорхойлно.
- 39.6. Арбитрч арбитрын ажиллагаа явуулах журмыг бичгээр гарган, гарын үсэг зуран баталгаажуулж талуудад хүргүүлнэ.
- 39.7. Арбитрч арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг 39 дүгээр зүйлийн 39.6 дахь хэсэгт заасан журмын дагуу явуулж хэргийг шийдвэрлэнэ.

Дөч. Хариуцлагаас чөлөөлөгдөх

- 40.1. Арбитрч, Бүрэлдэхүүн хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой үүргээ санаатайгаар зөрчсөнөөс бусад үйлдлийн төлөө аливаа хариуцлага хүлээхгүй.
- 40.2. Арбитрчид, Ажлын албаны дарга, ажлын албаны нарийн бичгийн дарга, ажилтнууд арбитрын ажиллагааны явцад санаатайгаар үүргээ зөрчсөн буюу ноцтой үр дагавар бүхий эс үйлдэл гаргаснаас бусад үйлдэл, эс үйлдлийн төлөө хариуцлага хүлээхгүй.

Дөчин нэг. Нууцлал

- 41.1. Бүрэлдэхүүн болон арбитрч, талууд, бусад оролцогсод, Ажлын албаны дарга, ажлын албаны нарийн бичгийн дарга, ажилтан, гэрч, шинжээч арбитрын ажиллагаанд оролцсон бүх этгээд Арбитрын ажиллагааны талаарх болон нотлох баримтын талаарх нууцыг хадгалах үүрэгтэй.
- 41.2. Арбитрын ажиллагаа явагдаж байгаа болон эцэслэн шийдвэрлэгдсэн хэргийн талаарх

мэдээ, мэдээллийг зөвхөн арбитрыг төлөөлж Ерөнхийлөгч эсхүл Ерөнхийлөгчөөс эрх олгосон этгээд мэдээлнэ.

- 41.3. Нэхэмжлэл гаргасан, спортын арбитрын хэрэг үүссэн болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцын мэдээг Ажлын албанаас өөрсдийн мэдээллийн сувгаар дамжуулан олон нийтэд мэдээлж болно.

**Дөчин хоёр. Арбитрын шийдвэрийг гүйцэтгэх шүүгчийн
захирамж, гүйцэтгэх хуудас, биелүүлэх ажиллагаа**

- 42.1. Арбитрын шийдвэрийг албадан биелүүлэх тухай болон гүйцэтгэх хуудас бичүүлэх тухай хүсэлт, арбитрын шийдвэр, шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон тодорхойлолтын хамт арбитрын ажиллагаа явагдсан тухайн орон нутгийн анхан шатны шүүхэд гаргана.
- 42.2. Шүүх хүсэлтийг хүлээн авсан нөхцөлд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хандаж арбитрын шийдвэрийг биелүүлэх арга хэмжээ авна.
- 42.3. Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитрын шийдвэрийг бусад улсад биелүүлэх бол Олон Улсад биелүүлэх Гадаадын Арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, гүйцэтгэх тухай 1958 оны Нью-Йоркийн конвенцид Монгол Улс 1994 онд нэгдэн орсон тул Спортын Арбитрын шийдвэрийг дээрх конвенцийн дагуу дэлхийн бусад улс оронд (энэ дүрэм батлагдах өдрийн байдлаар нийт 155 улс нэгдэн оржээ) гүйцэтгэнэ.
- 42.4. Спортын арбитрын шийдвэрийг гадаад улсад гүйцэтгэх бол 1958 оны Нью-Йоркийн конвенцийн заасан баримт бичгийг бүрдүүлэхээс гадна дээр дурдсан баримт бичгийг нэмэлтээр бүрдүүлнэ.

Дөчин гурав. Арбитрын шийдвэрийн биелэлтийг дүгнэх

- 43.1. Олон Улсад биелүүлэх Гадаадын Арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, гүйцэтгэх тухай 1958 оны Нью-Йоркийн конвенцид нэгдсэн улс оронд гүйцэтгэгдсэн шийдвэрийн талаар нэхэмжлэгч, эсхүл тухайн улсын холбогдох байгууллагаас лавлагаа авч хэрэгт хавсаргана.
- 43.2. Арбитрын шийдвэрийг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр гүйцэтгэсэн талаар лавлагааг нэхэмжлэгч, хариуцагч, шийдвэр гүйцэтгэх газраас лавлагаа авч хэрэгт хавсаргана.
- 43.3. Гадаад Улсын Спортын арбитрын шийдвэрийг Монгол Улсын нутаг дэвсгэрт биелүүлсэн тухай лавлагааг мөн холбогдох газраас авч, Монголын спортын арбитрын шийдвэрийг биелүүлсэн талаар нэгдсэн мэдээллийн санд оруулах ажиллагааг Ажлын алба хариуцан гүйцэтгэнэ.

Дөчин дөрөв. Дүрмийн хүчин төгөлдөр байдал

- 44.1. Энэхүү дүрэм 2023 оны 12 дугаар сары 01 -ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.